БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 10 сарын 07 өдөр Дугаар А/219 Улаанбаатар хот

Газар эзэмших, ашиглах эрхийн
дуудлага худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2020 оны 152 дугаар тогтоол, 2026 оны 45 дугаар тогтоол, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны А/188 дугаар тушаал, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны А/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 3 байршлын 3 нэгж талбарт газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдааг 2026 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр цахим хэлбэрээр зохих журмын дагуу зохион байгуулсугай.

2.Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, зориулалт, хэмжээ анхны үнийг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдааг зохих журмын дагуу зохион байгуулахыг Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

1226100628

AJIL\2026 он ажил\захирамж